



БОДЛОГЫН ТОЙМ: ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХУВЬЧЛАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2004 11 9 ажлууд нэгд

Оршил

Монгол улсын нийт гадаад өрийн тэн хагас нь эрчим хүчний салбарт ногдож байна. Хөнгөлөлттэй зээлийн ихэнхийг ирэх жилүүдээс эхлэн эргүүлэн төлөх учир Монгол улсын эдийн засаг болон эрчим хүчний аж ахуйн нэгжүүдэд ихээхэн бэрхшээл учрах юм. Салбарын аж ахуйн нэгжүүдийн өр өмчийн харьцааны зохистой харьцааг хангах цорын ганц арга нь хөрөнгийн дахин үнэлгээг үндэслэлгүйгээр хийх арга болжээ. Хөрөнгийн балансын үнэ тухайн хөрөнгийн зах зээлийн үнээс ихээхэн зөрүүтэй байгаа бөгөөд компаниудад бодит хөрөнгө оруулалт шаардагдаж байна. Засгийн газар хөрөнгө оруулалт хийх эх үүсвэргүй учир хувьчилна. Хувьчлалыг стратегийн хөрөнгө оруулагчид хүлээн авахаар, ил тод байдлаар явуулах нь зүйтэй.

Бусад оронтой харьцуулахад хөрөнгө оруулагчийн хүлээх эрсдэл Монгол улсад их учир эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах сонирхол бага байна. Сайтар боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулагчийн хүлээх эрсдлийг бууруулж болно. Хувьчлалыг эхлүүлэхээс өмнө хэд хэдэн зүйлийг хийсэн байх шаардлагатай. Салбарыг хувьчлах талаар шинэ Засгийн газрын хандлагыг боловсруулахад зориулан ЭЗБШӨЧТ-өөс дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Зөвлөмж

1. Хөрөнгө оруулагчийн эрсдлийг бууруулахын тулд хөрөнгийг 100% худалдахын оронд Концессийн тухай хуулийг батлан хэрэгжүүлэх,
2. Олон улсын хамгийн шилдэг туршлагад нийцүүлэн Эрчим хүчний тухай хуулийг өөрчлөн найруулах,
3. Хөрөнгө оруулагчийн эрсдлийг бууруулахын тулд бизнесийн холбогдолтой бусад хуулийг шинэчлэх,
4. ЭХЗГ-ыг бие даасан, хараат бус, үр дүнтэй зохицуулах байгууллага болгон хөгжүүлэхийг үргэлжлүүлэх,
5. Хувийн хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчийг татахын тулд зардлыг нөхөх, ашигтай ажиллах хэмжээнд тарифыг тогтоох,
6. Эрчим хүчний салбарын дотоод өр, авлагыг шийдвэрлэх,
7. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хорооноос баталсан стандартууд, Олон улсын санхүүгийн тайлангийн стандартуудад нягтлан бодох бүртгэлийг нийцүүлэх,
8. Мал сүрэг, амралтын газар зэрэг үндсэн бус үйл ажиллагаанаас татгалзахыг эрчим хүчний аж ахуйн нэгжүүдээс шаардах,
9. Олон улсын хөрөнгө оруулалтын банкирыг урьж, ил тод олон улсын тендер зарлан, тендер амжилтгүй болох эрсдлийг бууруулан нэг компанийг концессийн гэрээний дагуу хувьчлах,
10. Дамжуулах сүлжээ, Диспетчерийн үндэсний төв, Түлш эрчим хүчний ерөнхий газрыг хувьчлах талаар бодолцох,
11. Хөрөнгө оруулагчаас Засгийн газартай өрсөлдөх эрсдлийг бууруулахын тулд шинээр эрчим хүчний үүсгүүр барих төслийг хувийн хэвшилд буюу бие даасан цахилгаан станц (IPP) хөгжүүлэгчид өгөх,
12. Хувьчлахад төвөгтэй хөрөнгийн хувьд хөрөнгө оруулагчаас ямар нэгэн нөхцөлгүйгээр санал нээлттэй авах замаар худалдах аргыг бодолцох.

Бий болох боломжит өгөөжүүд

Гадаадын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын эрсдлийн урамшууллыг бууруулахыг хүсч байгааг макро эдийн засгийн бодлогоор үргэлжлүүлэн дэмжсэнээр дараах өгөөж бий болно Үүнд:

1. Эрчим хүчний салбарт хийх хөрөнгө оруулалтын шаардлага болон төсвийн хөрөнгийн эх үүсвэр хоёрын зөрүүг гадаадын болон дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг татах замаар нөхөх,
2. Олон улсын удирдлагын хамгийн сайн туршлагыг нэвтрүүлж, эрчим хүчний компаниудын үйл ажиллагааг (эрчим хүчний найдвартай хангамж, үйлчилгээний хамрах хүрээ, үр ашиг) сайжруулах,
3. Хөрөнгийн дахин үнэлгээг илүү бодитой авч үзвэл өрийн эзлэх хэмжээ ихтэй салбарын эрчим хүчний компаниудын санхүүгийн байдлыг сайжруулах,
4. Эрчим хүчний салбараас хамаарч нийт гадаад өр нэмэгдэхээс сэргийлж, Монгол улсын хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулах.

Мэдээллийн эх сурвалж

ЭЗБШӨЧТ-ийн "Бодлогын тойм: Эрчим хүчний салбарын өр ба хувийн хөрөнгө оруулалт" Улаанбаатар, 2004 оны 9 дүгээр сар.
ЭЗБШӨЧТ-ийн танилцуулга "Өмч хувьчлал: Хөрөнгө оруулагчийн зүгээс асуудалд хандах нь" Улаанбаатар, 2004 оны 4 дүгээр сар.
"Өмч хувьчлалын аргуудын хураангуй" ЭЗБШӨЧТ-ийн баримт бичиг. Улаанбаатар, 2004 оны 9 дүгээр сар.